



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГAA-2022/111/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483413	Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер:	Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055	Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>
	Аудитор	Ч.Даваасүрэн
	Утас: 99559722	Цахим хаяг: <a href="mailto:daavkach@gmail.com">daavkach@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 80

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07920093

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	12

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>26,317,133.53</b>	<b>31,671,660.80</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	299,782.73	24,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	24,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	24,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	26,017,350.80	31,647,660.80
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	988,600.00	988,600.00
35110	Тусгай зориулалттай материал	988,600.00	988,600.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25,028,750.80	30,659,060.80
35410	Бичиг хэргийн материал	796,650.00	796,650.00
35420	Аж ахуйн материал	15,189,409.00	15,853,409.00
35460	Хүнсний материал	1,356,380.00	722,690.00
35470	Бусад хангамжийн материал	7,686,311.80	13,286,311.80
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>283,947,341.37</b>	<b>277,582,820.35</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	283,947,341.37	277,582,820.35
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	215,687,341.37	209,412,820.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	208,565,924.80	208,565,924.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(49,563,537.84)	(72,281,106.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,754,687.93	58,223,302.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,163,597.82)	(15,172,231.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,189,881.54	38,526,079.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,760,466.46)	(10,838,898.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,130,500.00	6,130,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,249,050.78)	(5,523,750.90)
39217	Ном	1,783,000.00	1,783,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	68,260,000.00	68,170,000.00
39301	Програм хангамж	1,848,750.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,588,750.00)	(580,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	68,000,000.00	68,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>310,264,474.90</b>	<b>309,254,481.15</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>24,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	24,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	0.00	24,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	24,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	24,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>310,264,474.90</b>	<b>309,230,481.15</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	310,264,474.90	309,230,481.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	149,375,680.82	149,375,680.82
51101	Өмч: - төрийн	149,375,680.82	149,375,680.82
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	25,696,061.90	24,662,068.15
51210	Өмнөх үеийн үр дүн	25,696,061.90	25,696,061.90
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,033,993.75)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	135,192,732.18	135,192,732.18
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>310,264,474.90</b>	<b>309,254,481.15</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>484,310,833.70</b>	<b>376,909,880.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>121,970,233.70</b>	<b>757,080.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	121,970,233.70	757,080.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	121,970,233.70	757,080.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	121,970,233.70	757,080.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		757,080.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>362,340,600.00</b>	<b>376,152,800.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	309,438,600.00	330,054,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	309,438,600.00	330,054,900.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	52,902,000.00	46,097,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,902,000.00	46,097,900.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>373,858,203.16</b>	<b>377,943,873.75</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>373,858,203.16</b>	<b>377,943,873.75</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	343,970,357.44	366,214,413.38
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	230,847,479.14	239,792,036.13
210101	Үндсэн цалин	211,082,516.14	219,443,516.96
210104	Урамшуулал	19,764,963.00	20,348,519.17
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,608,772.00	30,963,004.51
210201	Тэтгэврийн даатгал	21,805,544.99	21,867,155.47
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,250,773.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,830,829.00	1,921,698.41
210204	Ажилгүйдлийн даатгал	452,073.00	442,425.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,520,325.00	4,480,951.48
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,632,339.62	42,702,936.72
210301	Гэрэл, цахилгаан	1,351,531.62	1,281,934.72
210302	Түлш, халаалт	33,089,876.00	37,997,900.00
210303	Цэвэр, бохир ус	6,190,932.00	3,423,102.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,723,400.37	6,187,980.00
210401	Бичиг хэрэг	799,300.00	901,700.00
210402	Тээвэр, шатахуун	240,000.00	240,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	799,400.37	699,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	166,000.00	224,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,718,700.00	4,122,480.00
2105	<b>Нормативт зардал</b>	14,098,130.00	9,095,935.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	240,000.00	550,000.00
210502	Хоол, хүнс	13,858,130.00	8,545,935.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	2,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	754,000.00	888,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210,000.00	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,306,236.31	34,584,521.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,406,236.31	34,084,521.02
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	29,887,845.72	11,729,460.37
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,760,000.00	1,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,760,000.00	1,600,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	8,271,460.38	1,370,963.28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,271,460.38	1,370,963.28
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	19,856,385.34	8,758,497.09
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,856,385.34	8,758,497.09
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>110,452,630.54</b>	<b>(1,033,993.75)</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	301157.44	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	301157.44	
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-301157.44	0.00
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>110,151,473.10</b>	<b>(1,033,993.75)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	149,375,680.82	135,192,732.18	25,696,061.90	0.00	310,264,474.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>149,375,680.82</b>	<b>135,192,732.18</b>	<b>25,696,061.90</b>	<b>0.00</b>	<b>310,264,474.90</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>149,375,680.82</b>	<b>135,192,732.18</b>	<b>25,696,061.90</b>	<b>0.00</b>	<b>310,264,474.90</b>
<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>149,375,680.82</b>	<b>135,192,732.18</b>	<b>25,696,061.90</b>	<b>0.00</b>	<b>310,264,474.90</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>149,375,680.82</b>	<b>135,192,732.18</b>	<b>25,696,061.90</b>	<b>0.00</b>	<b>310,264,474.90</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,033,993.75	0.00	-1,033,993.75
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>149,375,680.82</b>	<b>135,192,732.18</b>	<b>24,662,068.15</b>	<b>0.00</b>	<b>309,230,481.15</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>362,340,600.00</b>	<b>376,152,800.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>362,340,600.00</b>	<b>376,152,800.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	309,438,600.00	330,054,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	309,438,600.00	330,054,900.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	52,902,000.00	46,097,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,902,000.00	46,097,900.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>362,340,600.00</b>	<b>348,432,800.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>362,340,600.00</b>	<b>348,432,800.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>332,452,754.28</b>	<b>336,703,339.63</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	231,044,932.29	239,492,252.79
210101	Үндсэн цалин	211,279,969.29	219,143,733.62
210104	Урамшуулал	19,764,963.00	20,348,519.17
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,608,772.00	30,963,005.12
210201	Тэтгэврийн даатгал	21,805,545.00	21,867,155.47
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,250,773.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,830,829.00	1,921,698.41
210204	Ажилгүйдлийн даатгал	452,073.00	442,425.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,520,325.00	4,480,952.10
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,630,539.62	42,726,936.72
210301	Гэрэл, цахилгаан	1,351,531.62	1,179,346.72
210302	Түлш, халаалт	33,088,076.00	37,997,900.00
210303	Цэвэр, бохир ус	6,190,932.00	3,549,690.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,963,400.37	6,070,900.00
210401	Бичиг хэрэг	799,300.00	901,700.00
210402	Тээвэр, шатахуун	240,000.00	240,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	799,400.37	699,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	376,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,718,700.00	4,029,400.00
2105	<b>Нормативт зардал</b>	17,761,110.00	8,462,245.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	240,000.00	550,000.00
210502	Хоол, хүнс	13,537,310.00	7,912,245.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	2,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	544,000.00	888,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	900,000.00	6,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	6,100,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,887,845.72</b>	<b>11,729,460.37</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,760,000.00	1,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,760,000.00	1,600,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	8,271,460.38	1,370,963.28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,271,460.38	1,370,963.28
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	19,856,385.34	8,758,497.09
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,856,385.34	8,758,497.09
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>0.00</b>	<b>27,720,000.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.00</b>	<b>27,720,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>27,720,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>27,720,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		27,720,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>(27,720,000.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	376,152,800.00	366,023,339.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	376,152,800.00	366,023,339.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,552,800.00	364,423,339.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	241,724,000.00	239,492,252.79
210101	Үндсэн цалин	220,762,000.00	219,143,733.62
210104	Урамшуулал	20,962,000.00	20,348,519.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,769,200.00	30,963,005.12
210201	Тэтгэврийн даатгал	23,137,200.00	21,867,155.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,635,900.00	2,250,773.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,148,300.00	1,921,698.41
210204	Ажилгүйдлийн даатгал	533,000.00	442,425.84
210205	Эрүүл мэндийн даатгал	5,314,800.00	4,480,952.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,097,900.00	42,726,936.72
210301	Гэрэл, цахилгаан	1,500,000.00	1,179,346.72
210302	Түлш, халаалт	37,997,900.00	37,997,900.00
210303	Цэвэр, бохир ус	4,600,000.00	3,549,690.00
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	6,168,000.00	6,070,900.00
210401	Бичиг хэрэг	902,000.00	901,700.00
210402	Тээвэр, шатахуун	240,000.00	240,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700,000.00	699,800.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариут	296,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,030,000.00	4,029,400.00
2105	Нормативт зардал	14,805,700.00	11,182,245.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	550,000.00	550,000.00
210502	Хоол, хүнс	11,535,700.00	7,912,245.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,720,000.00	2,720,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,000,000.00	27,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	888,000.00	888,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	240,000.00	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,100,000.00	6,100,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,100,000.00	6,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,600,000.00	1,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,600,000.00	1,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,600,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>376,152,800.00</b>	<b>366,023,339.63</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	330,054,900.00	321,296,402.91
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	330,054,900.00	321,296,402.91
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,097,900.00	44,726,936.72
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,097,900.00	44,726,936.72

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудиторын туслах Ч.Даваасүрэн гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дах Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, хүүхдийг бие бялдарын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх ариун цэвэр эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох, хэл яриа сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх хүрээлэн байгаа орчин юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлийг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 435.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 7.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.3 хувиар буюу 1.0 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 31.6 сая төгрөг болж 5.6 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 21.7 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 16.8 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 31.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 277.5 сая төгрөг болж 6.3 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 27.7 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч 7.0 сая төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 309.2 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 3.8 хувиар буюу 14.0 сая төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 24.6 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 422.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс 6.7 сая төгрөгөөр бууруулж, 376.1 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь норматив зардал багассантай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 376.1 сая төгрөгийн төсөв баталснаас 330.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 46.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 46.1 сая төгрөг, улсын төсвөөс 330.0 сая төгрөгийн санхүүжилт авч 376.1 сая төгрөгийн нийт орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 366.0 сая төгрөгийг зарцуулж 8.7 сая төгрөгийг улсын төсөвт, 1.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 366.0 сая төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 2.2 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 2.8 сая төгрөг, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1.4 сая төгрөг, нормативт зардлыг 3.7 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 369.7 сая төгрөгийн 148 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 144 мэдээлэл, хугацаа хоцорч 3 мэдээлэл мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 1.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн чанар, ашиглалтын байдал
- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанар, үнэнд дүн шинжилгээ хийх

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6.4 сая төгрөгийн зөрчил, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

### 4.2 Албан шаардлага

- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр 5.2 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт" ТБОНӨХ-өөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ
- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.1-д" Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Хөндлөнгийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад 1.2 сая төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т

"Төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэг	3	6.4	-	-	-	-	3	6.4	-	